



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны жилийн эцсээр хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан мэдээнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүнгийн тухай Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Т.Оюунчимэг танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:


1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны жилийн эцсээр хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн мэдээг холбогдох журмын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/-т;

2. Хариуцсан салбарын чиглэлээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, гүйцэтгэлийг тооцон ажиллахыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн гишүүдэд;

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагын хариуцлага, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглүүлж, нийслэлийн удирдлагыг бодит мэдээллээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Х.Гантулга/-т;

4. Хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийг хангах ажлыг ажилбар тус бүрээр задлан байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, гүйцэтгэлийн явц, үр дүнг байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцэж, удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



111020000033